# ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ, АР НАЙМГАНЫ ДООД ХЭСЭГ НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРД 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-015479 /

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5292638 /

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын шинжээч ............................................................./ /

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын

газрын мэргэжилтэн................................................/ С.Эрдэнэцогт /

Биелэлтийг тайлагнасан:

“Редвулкан” ХХК-ийн гүйцэтгэх захиарал....................................................../ Л.Мөнхсайхан /

“Редвулкан” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн......................................../ Э.Намсрай /

2022 он

ГАРЧИГ

1.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 4
1.1 ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 5
2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 5
2.1 Агаар орчин ........ 5
2.2Усны нөөц, чанар ........ 7
2.3 Хөрсөн бүрхэвч ........ 8
2.4 Ургамал, амьтны аймаг ........ 10
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 11
4.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12
5.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 12
6.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 12
7.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 12
8.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 15
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 17
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 19
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 20

ЗУРГЫН ЖАГСААЛТ

Зураг.1 Замын тоос дарах усалгаа....................................................................................4
Зураг.2 Засварын бүртгэл....................................................................................................5
Зураг.3 Хурдны хязгаар заасан тэмдэг...............................................................................5
Зураг.4 Засварын талбайн хөрс............................................................................................6
Зураг.5 Үерийн уснаас хамгаалах шуудуу..........................................................................8
Зураг.6 Унд ахуйн худгийн хашаажуулалт хийв...............................................................8
Зураг.7 Асгаралт үүссэн тохиолдолд авах арга хэмжээ....................................................9
Зураг.8 Шимт хөрсний овоолго............................................................................................9
Зураг.9 Салаа зам үүссэнийг хаав.....................................................................................10
Зураг.10 Байгаль хамгаалах сургалтад оров.....................................................................10
Зураг.11 Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явц.........................................................11
Зураг. 12 Мод тарилт хийв.................................................................................................11
Зураг.13 Гал унтраах үзүүлэх сургалт...............................................................................13
Зураг.14 Уурхайн шатахуун хадгалах газар.......................................................................13
Зураг.15 Уул уурхайн аврах 09 дүгээр аврах ангийн сургалт..........................................14
Зураг.16 Засварын талбай...................................................................................................14
Зураг.17 Ангилан ялгалтын хогийн сав.............................................................................15
Зураг.18 Хатуу хог хаягдал түр хадгалах цэг....................................................................15
Зураг.19 Хог хаягдал тээвэрлэж буй зураглал..................................................................16
Зураг.20 Баяжуулах үйлдвэрийн хаягдлаар дэвсэлт хийж ажилав..................................16
Зураг.21 Засварын талбайн тослох материалын агуулахад байрлаж буй зураглал..........16
Зураг.22 Засварын талбайн хаягдал тос нийлүүлэлт хийгдэж буй зураглал...................17
Зураг.23 Уурхайн тоосонцорын хэмжилт хийгдэж буй зураглал.....................................17
Зураг.24 Дуу чимээний хэмжилт хийгдэж буй ажлын явц...............................................18
Зураг.25 Баяжуулахын нуураас, болон унд ахуйн худ усны дээж авч буй зураглал.......18
Зураг.26 Засварын талбай, штс, шимт хөрсний овоолгоос хөрсний дээж авав..............18
Зураг.27 Байгаль орчны сургалтыг нийт ажилчдад танилцуулж буй зураглал..............19

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

*Хавсралт.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ*

*Хавсралт.2 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл*

*Хавсралт.3 Лавлагаа*

*Хавсралт.4 Усны гэрээ, дүгнэлт*

*Хавсралт.5 Газар эзэмшүүлэх гэрээ*

*Хавсралт.6 Нөхөн сэргээлтийн 50% барьцаа байршуулсан баримт*

*Хавсралт.7 Ус ашигласан төлбөр төлсөн баримт*

*Хавсралт.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

*Хавсралт.9 Палеонтологи, археологи, ажлын тайлан дүгнэлт*

*Хавсралт.10 Хог хаягдлын гэрээ*

*Хавсралт.11 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил*

*Хавсралт.12 2022 оын Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө*

# 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журмын дагуу боловсруулаа. Төв аймгийн Заамар сумын нутаг орших Ар наймганы доод хэсэг нэртэй алтны шороон ордыг 2022 онд олборлох явцад эвдрэлд өртсөн 3 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг ордын уул техникийн нөхцөлтэй уялдуулан хийж гүйцэтгэв.

Уг алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсанүнэлгээний тайлангийн тодотголыг “Төгрөг баянхангай” ХХК 2021 онд хийж батлуулсан. Ашиглалтын MV-015479 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Төв аймгийн Заамар сумын “Ар наймганы доод хэсэг” нэртэй газарт оршино.

| | | |
|---|---|---|
| Төслийн нэр: | “Ар наймганы доод хэсэг” нэртэй алтны шороон орд | |
| Төслийн ангилал: | “Байгаль орчны үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн хавсралтын дагуу “Уул уурхайн төсөл” ангилалд хамаарна. | |
| Төслийн дугаар: | MV-015479 | |
| Талбайн хэмжээ: | 168.7 га | |
| Төсөл хэрэгжүүлэгч: | “Редвулкан” ХХК | |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, нарны зам, 143, 5 тоот |

| | |
|---|---|
| Төслийн байршил: | Төсөл хэрэгжүүлэх талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах “Ар наймганы доод хэсэг” нэртэй газарт оршино. Төслийн талбай Заамар сумаас 30 км, “Шижир алт” ХХК, “Алтан дорнод Монгол” ХХК-ий уурхайн суурин бүхий Өгөөмөр багийн төв, Хайлаастын тосгоноос 13 км, Улаанбаатар хотоос 249 км-т байрлана. |

Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Ар наймганы доод хэсэг нэртэй газарт орших MV-01579 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг Монгол Улсад бүртгэлтэй “Аварга тосон хэнтий” ХХК-д АМГТХЭГ-ын даргын 2010 оны 02-р сарын 12-ны өдрийн шийдвэрээр олгосон юм. 2012 онд “Рэдвулкан” ХХК-д шилжүүлсэн байна.

## 1.1 ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уурхайн бэлтгэл ажил 2022 оны 02-р сарын 15-с эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд тоног төхөөрөмжүүдийг ажлын талбайруу татах, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах зэрэг ажил хийгдэнэ. 2022 оны 03-р сарын эхэн үеэс ордын бэлтгэл ажлыг эхлүүлж 4-6-р сарын хооронд 2 сар 20 хоногийн хугацаанд хөрс хуулалт болон элс олборлолтын ажлыг явуулсан бөгөөд энэ хугацаанд MV-015479 тоот ашиглалтын лиценз дэх дээд давхаргын 4-В, доод давхаргын 1-С, 2-В, 3-В блокийг бүхэлд нь олборлохоор төлөвлөсөнөөс дээд давхаргын 4-В, доод давхаргын 4-В,5-В блокийг авсан. Уг блокоос 1 088.489 мян.м3 уулын ажил хийгдэж, 56.353 мян.м3 элс олборолтын ажил гүйцэтгэсэн.

2022 төлөвлөгөөгөөр ашиглалтын үйл ажиллагаагаар 14.4 га талбайг эвдрэлд оруулах байсанаас 3.66 га талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулсан. Үйл ажиллагаа явуулахад эвдрэлд орсон 3.66 га талбайн 7,32 мян.м3 үржил шимт хөрсийг хуулж, хадгалсан. Шимт хөрсний овоолго болон техникийн нөхөн сэргээлт хийхдээ холбогдох хууль, журам, стандартыг баримтлан хийсэн болно.

# 2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1 Агаар орчин

### 2.1.1 Уурхайн технологийн замыг усалж чийглэх

Уурхайн авто замуудыг болон ажлын талбайг дулааны улиралд болон тоос ихээр босох үед тогтмол усалгаа хийж чийгшүүлэн тоосжилтыг бууруулан ажилласан бөгөөд 10 м/с-ээс дээш салхитай нөхцөлд уурхайн ажлыг түр зогсоон ажиллаж байв.



*Зураг.1 Замын тоос дарах усалгаа*

### 2.1.2 Хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг тогтмол явуулах

Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг сар болгон хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээ, бохирдлыг стандартуудын шаардлага хангах хэмжээнд байлгах тал дээр анхааран мото цагийн болон бусад тохиргоо үйлчилгээг сар бүр хийн ажиллаж байв.




*Зураг.2 Засварын бүртгэл*

### 2.1.3 Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах

Уурхайн зам дээрх тээврийн хэрэгслийн явах хурдыг хязгаарлах нь тоосжилтыг хянах үр дүнтэй аргуудын нэг юм. Хурдыг 40 км/цаг-с 16 км/цаг болгож бууруулахад замаас үүсэх 10 микроноос бага ширхэгтэй тоосонцрын хэмжээ 58%-иар, 40 км/цаг-с 24 км/цаг болгоход 42%-иар тус тус буурах боломжтойг судалгаагаар тогтоосон байдаг. Тээврийн болон уурхайн замд хурдны хязгаар заасан тэмдэг тэмдэглэгээ байршуулж, уурхайн автозамын хөдөлгөөний дүрэм журмыг мөрдөн, автотээврийн хэрэгслийн хурдыг тогтмол хянаж ажилласан.




*Зураг.3 Хурдны хязгаар заасан тэмдэг*

### 2.1.4 Агаарын тоосны (TSP, $PM_{10}$, $PM_{2.5}$) шинжилгээг хийлгэх

Орчны хяналт шинжилгээний хүрээнд агаарын тоосны хэмжилт хийгдсэн.
*Хавсралт.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

*Хүснэгт.1*

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | Нийт тоосонцорын агууламж /TSP/ мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|
| ***1*** | Карьер | V/09 | 0.020 | 0.019 | 0.096 | 40 |
| ***2*** | Карьер | V/09 | 0.013 | 0.015 | 0.085 | 35 |
| ***3*** | Карьер | V/09 | 0.119 | 0.010 | 0.082 | 40 |
| | Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 | | ***0.450*** | ***0.200*** | ***0.500*** | ***60*** |

### 2.2 Усны нөөц,чанар

### 2.2.1 Хөрсний орчинд шатах тослох материал алдагдахаас сэргийлэх

Машин засварын газар болон авто зогсоолуудыг хатуу хучилттай болгох ажлын тал дээр мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажилласан бөгөөд 1-2 жил ажиллах шороон ордын хувьд хатуу хучилт нь эргээд байгаль орчинг бохирдуулах эх үүсвэр болдог. Баяжуулалтын хаягдал болох гаалиар 20 см-ийн зузаантай дэвсэлт хийн дагтаршуулж хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэн ажилласан.



*Зураг.4 Засварын талбайн хөрс*

### 2.2.2 Ус ашиглалтын гэрээний дагуу төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах

*Хавсралт.7 Усны гэрээ дүгнэлт төлбөр төлсөн баримт*

**2.2.3 Төсөл хэрэгжих талбайд хаврын шар усны үерийн болон гадаргын усны урсцаас хамгаалах зорилгоор шуудуу байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах**

Уурхайн ухаш болон, үерийн ус орж болзошгүй хэсгүүдэд шуудуу татаж ажилласан.



*Зураг.5 Үерийн уснаас хамгаалах шуудуу*

**2.2.3 Худгийн эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоох, сэргээн засварлах**

Унд ахуйн худгийн бүст эрүүл ахуйн 50м-ийн бүс тогтоож хашаажуулав.



*Зураг.6 Унд ахуйн худгийн хашаажуулалт хийв.*

**2.3 Хөрсөн бүрхэвч**

**2.3.1 Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах**

Засварын талбайд асгаралт болсон тохиолдолд spill kit байрлуулан асгаралтын арга хэмжээг авч ажилласан. Мөн асгаралтын журам гаргаж ажилчдад танилцуулсан.



*Зураг.7 Асгаралт үүссэн тохиолдолд авах арга хэмжээ*

**2.3.2 Тусгай зөвшөөрлийн дагуу ашигт малтмал болон газар ашиглах гэрээний дагуу газрын төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах**

*Хавсралт.5 Газрын гэрээ,гэрчилгээ төлбөр төлсөн баримт*

**2.3.3 Үржил шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хэлбэржүүлж засах**

Орчны хяналт шинжилгээний хүрээнд шимт хөрсний овоолгоос хөрсний дээж шинжилгээнд хүргүүлсэн бөгөөд стандартын дагуу шимт хөрсний овоолгыг байршуулсан болно.



*Зураг.8 Шимт хөрсний овоолго*

*Хүснэгт.2 шимт хөрс биологи хийсэн талбай*

| *Дээжний дугаар* | **pH H2O (1:5)** | **CaCO3 %** | **Ялзмаг %** | **EC2.5 dS/m** | **Хөдөлгөөнт мг/100г** | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | P2O5 | K2O |
| | 7.30 | 0.00 | 3.696 | 0.138 | 2.74 | 26.1 |

| *Дээжний дугаар* | **Ширхэгийн хэмжээ, (% мм-ээр)** | | |
|---|---|---|---|
| | 46.9 | 39.5 | 13.6 |
| | Элс (2-0.05 мм) | Тоос (0,05-0,002 мм) | Шавар (<0.002 мм) |

Шимт хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцар.

### 2.3.4 Төслийн төлөвлөгдсөн талбайгаас гадна машин техник явуулахгүй байх

Уурхайн аюулгүй ажиллагаа, автозамын дүрэмд заасны дагуу төслийн төлөвлөгдсөн талбайгаас гадна машин техник явуулахгүй байхыг тусгаж өгсөн ба хэрэгжилтийг ханган ажилласан. Салаа зам үүссэнийг хааж, анхааруулга сануулга өгж ажиллав.



*Зураг.9 Салаа зам үүссэнийг хаав.*

## 2.4 Ургамал, амьтны аймаг

### 2.4.1 Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх, замын нэгдсэн сүлжээг гаргах. Ан амьтан агнахгүй байх, байгаль хамгаалах талаар сургалт явуулах

Уурхайн аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний дүрэмд маршрутын бус замаар хөдөлгөөнд оролцохын хязгаарлаж өгсөн ба ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх байгаль хамгаалах талаар сургалт явуулж ажиллаа. Мөн ан агнуур хориотой тэмдэг байршуулсан.




*Зураг.10 Байгаль хамгаалах сургалтад оров.*

# 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 3.1 Техникийн нөхөн сэргээлт

2022 онд нийт 3 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 2022 төлөвлөгөөгөөр ашиглалтын үйл ажиллагаагаар 14.4 га талбайг эвдрэлд оруулах байсанаас 3.66 га талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулсан. Үйл ажиллагаа явуулахад эвдрэлд орсон 3.66 га талбайн 7.32 мян.м3 үржил шимт хөрсийг хуулж, хадгалсан. Шимт хөрсний овоолго болон техникийн нөхөн сэргээлт хийхдээ холбогдох хууль, журам, стандартыг баримтлан хийсэн болно.



*Зураг.11 Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явц*

## 3.2 Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтэд 5 сард 1111 ширхэг мод тарьсан ба үүнээс 600 ширхэг улиас 511 ширхэг хайлаас мод тарьсан болно.



*Зураг. 12 Мод тарилт хийв*

## 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай.

Тус ажлын хүрээнд лицензийн талбайн ойролцоо эврэлд орсон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн.

## 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад нүүлгэн шилжүүлэн, нөхөн олговор олгохарга хэмжээний ажил хийгдэхгүй болно.

## 6.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Палеонтологи хайгуул, судалгааны ажлын дүгнэлт. Тус ордын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд палеонтологийн судалгааг ШУА-ийн палеонтологи, геологийн хүрээлэнгийн баг хамт олноор гүйцэтгүүлсэн. Тус ажлыг явуулахдаа Монгол успын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8 дугаарт заасны дагуу ажилласан байна. Судалгааны талбайн хэмжээнд эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна.

Цаашид тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд ашиглалт явуулах үе шатанд палеонтологийн сонирхолтой үнэт ховор олдвор илэрсэн тохиолдолд олборлолтын ажлыг түр зогсоож холбогдох байгууллагуудад хандан авран хамгаалах малтлага хийлгэх хэрэгтэй гэж үзсэн байна. Тус судалгаа шинжилгээний ажлын дэлгэрэнгүйг хавсралт материалаар хавсаргав.

Түүх-Археологийн авран хамгаалах судалгааны ажлын дүгнэлт. Тус ордын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27.8, 27.9, болон Соёлын өвийн судалгаа хийх журмын 2 дугаар бүлгийн 2.1.2 болон 3.1 зэрэг заалтуудыг баримтлан тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд тархсан эртний булш болон эртний түүх соёлын хөшөө дурсгалуудыг тогтоолгох зорилгоор ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Археологи, Угсаатан зүйн авран хамгаалах салбарын мэргэжилтэнгүүдээр археологийн судалгааг гүйцэтгүүлсэн. Тус ажлын үр дүнд археологийн олдвор илрээгүй.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17.10, 17.12, болон “Монгол улсын нутаг дэвсгэр дээр археологи, палеонтологийн хайгуул, малтлагаа судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дугаар заалтуудыг үндэслэн түүх-археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтанд анхааран, хөрс хуулалт, хүдэр олборлолтын үйл ажиллагаа явуулах тохиолдолд хэрвээ дурсгал илэрвэл малтан судалж, талбайг чөлөөлүүлэх шаардлагатай хэмээн үзсэн байна.
*(Хавсралт.10 Палеонтологи, археологи, ажлын тайлан дүгнэлт)*

## 7.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах.

**7.1.1 Болзошгүй аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, нийт ажилтанд танилцуулж, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг гаргаж, зааварчлагаа өгөх.**

Болзошгүй аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан. Батлагдсан төлөвлөгөөний нүүрийг *Хавсралт.10* т тусгав. Мөн нийт ажилчдад аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцуулсан.

### 7.1.2 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тогтмол явуулж ажилласан ба гал унтраах үзүүлэх сургалт зохион байгуулсан.



*Зураг.13 Гал унтраах үзүүлэх сургалт*

### 7.1.3 Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахыг гадаргын урсцаас хамгаалах ба тэдгээрээр бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу байгуулах

Уурхайн нефтийн бүтээгдэхүүн агуулах болон хаягдал тос хадгалах хэсгүүдэд далан байгуулсан болно.




*Зураг.14 Уурхайн шатахуун хадгалах газар*

### 7.1.4 Уурхайлалтын үед гарж болзошгүй нуралт, гулсалт гэх мэт аваар ослын талаар ажиллагсдад ойлгуулж, түүнээс сэргийлэх

“Ред вулкан” ххк 2022оны 4-р сарын 28 ны өдөр Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр аврах ангитай хамтран Уурхай, уулын үйлдвэрт ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг олгох сургалт зохион байгуулж сургалтын хүрээнд ОБЕГ-ын дэргэдэх Уул уурхайн аврах

09 дүгээр ангийн танилцуулга, Аюулгүй ажиллагааны зааварчилгааны төрөл, тэдгээрийн ангилал, агуулга, Ил уурхайн үйлдвэрлэлийн технологийн үндэс, Ил уурхайн ажлын байрны нөхцөл,Тоосны тухай, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, Ил уурхайн үндсэн процэссүүдийн аюулгүй ажиллагаа ( Өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих, тээвэрлэлт, овоолго ) Уурхай, уулын үйлдвэрлэлийн эрүүл ахуйтай холбоотой эрх зүйн орчин, Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, Эрүүл мэндийн анхны тусламж, Уулын нуралт гулсалтын тухай, Аюулын дүн шинжилгээ хийх – Ил уурхай. Сэдвүүдээр ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр аврах ангийн захирагчийн орлогч, штабын дарга, хошууч Б.Алтан-Очир, ахмад Ц.Цэнгэлмаа, хошууч Д.Санжаасүрэн нарын бүрлдхүүнтэйгээр хамтран зохион байгуулсан сургалтад оролцсон.



*Зураг.15 Уул уурхайн аврах 09 дүгээр аврах ангийн сургалт*

**7.1.5 Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, шатах тослох материал хадгалах, машин техникийг цэнэглэх ажлыг зориулалтын талбайд явуулах**

Засвар үйлчилгээг тусгайлан бэлдсэн талбайд хийж ажилласан бөгөөд асгаралт үүсэх болзошгүй тохиолдол бүрд анхааран ажилласан.




*Зураг.16 Засварын талбай*

# 8.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 8.1 Ахуйн хог хаягдал

### 8.1.1 Уурхайн талбай болон тосгонд стандартын шаардлага хангасан, ангилан ялгах тэмдэглэгээ бүхий хогийн сав байршуулах

Хуванцар, шил лааз, цаас зэрэг дахивар хог хаягдлуудыг ангилан ялгалтын саванд цуглуулсан.




*Зураг.17 Ангилан ялгалтын хогийн сав*

### 8.1.2 Хог хаягдлын түр хадгалах цэгийг тохижуулах, хашаажуулах.

Ахуйн хатуу хог хаягдлын цэг байгуулж, хашаажуулан тохижуулж ажилласан.




*Зураг.18 Хатуу хог хаягдал түр хадгалах цэг*

### 8.1.3 Заамар сумын ЗДТГ-тай Хог хаягдлын гэрээ хийх.

*Хавсралт.11 Хог хаягдлын гэрээ*

### 8.1.4 Орон нутагтай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу ангилан ялгасан хог хаягдлыг холихгүйгээр хаях.

Уурхайн хог хаягдлыг 2 хоног тутамд сумын нэгдсэн хог хаягдлын цэг рүү тээвэрлэсэн.



*Зураг.19 Хог хаягдал тээвэрлэж буй зураглал.*

**8.2 Үйлдвэрийн хог хаягдал**

**8.2.1 Баяжуулах үйлдвэрээс том жижиг ширхэгтэй чулуулаг гарах ба олборлолтын явцад дотоод нөхөн дүүргэлтэд ашиглана**.

Баяжуулах үйлдвэрээс том жижиг ширхэгтэй чулуулагыг дотоод нөхөн дүүргэлт болон зам талбай янзлах засварын талбайн суурь хийхэд ашигласан.



*Зураг.20 Баяжуулах үйлдвэрийн хаягдлаар дэвсэлт хийж ажиллаа.*

**8.3 Аюултай хог хаягдал**

**8.3.1 Ашиглагдсан тос, тослогооны материал, аккумляторыг тусгай цэг гарган хуримтлуулах**



*Зураг.21  Засварын талбайн тослох материалын агуулахад байрлаж буй зураглал*

**8.3.2Ашигласан тос тослогооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх**

Ажилласан тос тослогооны материалыг “ Монпити ойл” ххк хүлээлгэн өгсөн.




*Зураг.22 Засварын талбайн хаягдал тос нийлүүлэлт хийгдэж буй зураглал*

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

**10.1Агаарын чанар**

Хүхэрлэг хий (SO2), Азотын давхар исэл (NO2), Нийт тоосонцор.

Уурхайн агаарын чанар, тоосонцорын судалгааг хийсэн. Судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн бөгөөд тооцооллыг хавсралтаар оруулав.




*Зураг.23 Уурхайн тоосонцорын хэмжилт хийгдэж буй зураглал*

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | Нийт тоосонцорын агууламж /TSP/ мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|
| ***1*** | Карьер | V/09 | 0.020 | 0.019 | 0.096 | 40 |
| ***2*** | Карьер | V/09 | 0.013 | 0.015 | 0.085 | 35 |
| ***3*** | Карьер | V/09 | 0.119 | 0.010 | 0.082 | 40 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 | | | ***0.450*** | ***0.200*** | ***0.500*** | ***60*** |

3 цэгт хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосонцорын агууламж, дуу чимээг хэмжиж үзэхэд стандарт үзүүлэлтээс давсан үзүүлэлт байхгүй байна.

### 10.1.1 Дуу шуугианы хэмжилт хийх.

Дуу чимээний хэмжилтийг 3 цэгт хийсэн. Уурхайн карьерт, дотоод овоолго, засварын талбайд дуу чимээний хэмжилтийг боловсруулсан. Хэмжилтийн тооцоог хавсралтад оруулав.



*Зураг.24 Дуу чимээний хэмжилт хийгдэж буй ажлын явц*

### 10.2 Уурхайн унд-ахуйн усны зориулалттай гүний худаг,Үйлдвэрийн ус цуглуулах эргэлтийн усан сан

Уурхайн унд-ахуйн ус болон худаг, баяжуулахын цэвэр нуур, бохир нууруудаас усны дээж шинжилгээг хийсэн. Шинжилгээний хариуг хавсралтаар оруулав.



*Зураг.25 Баяжуулахын нуураас, болон унд ахуйн худ усны дээж авч буй зураглал*

### 10.3 Хөрсөн бүрхэвч

Ялзмагийн агууламж, pH, давсжилт, чийгшил,NO3-N, P2O5, K2O,pH, нийт азот, нийт фосфор.




*Зураг.26 Засварын талбай, штс, шимт хөрсний овоолгоос хөрсний дээж авав.*

# 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 11.1 Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах

Манай компани нь орон тооны байгаль орчны мэргэжилтэн ажиллуулж байгаа нь нөхөн сэргээлт, байгаль орчин хамгаалах ажлууд үр дүнтэй болох ба бид цаашид монгол улсад мөрдөж байгаа стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилго тавин ажиллаж байна.

## 11.2 Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

Гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;/2 жил тутамд/

Ашиглалтын эхний жилдээ ажиллаж байгаа тул хуваарьт аудитын хугацаа болоогүй болно

## 11.3 Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах

Байгаль орчны мэргэжлийн байгууллага “ Газар чандмань” ххк-аар 2022.05-р сарын сургалтаар Монгол орны ургамлын аймгийн тухай ерөнхий мэдлэг олгох, уурхайн ойролцоо түгээмэл тархсан хөл газрын ургамлуудыг таних, тэдгээртэй тэмцэх арга замуудыг зөвлөх сэдвээр нийт ажилчдад сургалт орсон.



*Зураг.27 Байгаль орчны сургалтыг нийт ажилчдад танилцуулж буй зураглал.*

## 11.4 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх/5 жил тутамд/

*Хавсралт.12 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил*

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 12.1 Заамар сумын Хайлааст багийн иргэд

Уурхайн нөлөөллийн бүсэд орших малчдад нөхөн сэргээлт болон "Тэрбум мод" ажлын хүрээнд тарьсан модны суулгац амьдралын хувь зэргийг танилцуулсан.

### 12.2 Төв аймгийн Байгаль орчны газар

Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материалыг хүргүүлэв.

### 12.3 Төрийн захиргааны төв байгууллага

Холбогдох ажлын акт гарсны дараа БОАЖЯ-ны ХБОНУГ-т ажлаа тайлагнах болно.

### 12.4 Тухайн жилийн зардлын хүснэгт

| Д/д | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Үнийн дүн / мян.төг / |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 0.63 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | - |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 6.089 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | - |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1.0 |
| 7 | Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал | 0.5 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) | 2.4 |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | - |
| 10 | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | - |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт зардал | | 10.61 |

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000206258

2009.03.24
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011187051
/ Хувийн хэргийн дугаар /

5292638
/ Регистрийн дугаар /

Рэдвулкан Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 2009.03.23 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 4610 | Гадаад худалдаа |
| 4659 | Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа |
| 7730 | Уул уурхайн тоног төхөөрөмжийн түрээс |
| 0990 | Ашигт малтмалын ашиглалт |
| 0899 | Ашигт малтмалын ашиглалт/2010.02.12-2037.02.09/ /2010.02.12-2037.02.09/ |

| Хугацаагүй | 1 | 1,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянзүрх, 25-р хороо, нарны зам, 143, 5 тоот, Утас1: 99112483, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

МОНГОЛ УЛС МОНГОЛ УЛС МОНГОЛ УЛС

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2020 он 06 сар 17 өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Гочоо овогтой Одмандах-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2020.06.17 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2020.06.17 | Э.Эрдэнэбилэг |
| 3 | Улаанбаатар, Сүхбаатар, 7-р хороо, 11 хороолол, эрхүүгийн, 10, 128 тоот Утас1: 99110737, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2020.06.23 | Ж.Нямдорж |
| 4 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдсж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.06.23 | Ж.Нямдорж |
| 5 | Эрдэнэсүрэн овогтой Оргил-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2020.06.23 | Ж.Нямдорж |
| 6 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020.06.23 | Ж.Нямдорж |
| 8 | Хувьцаа эзэмшигч 3 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.05.25 | С.Мөнхсанчир |
| 9 | Лхагвасүрэн овогтой Мөнхсайхан-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.05.25 | С.Мөнхсанчир |
| 10 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2021.05.25 | С.Мөнхсанчир |
| 11 | Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, их монгол улс, хансвилл, 103, 802 тоот Утас1: 99071229, Утас2: 99041519, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2021.05.25 | С.Мөнхсанчир |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*000206258*

## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

## АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

***Дугаар 15479А***

**Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн**

*Төв* **аймаг /хот/-ийн**

*Заамар* **сум /дүүрэг/-ын**

*Аршайлганы дээд хэсэг* **нэртэй газарт орших**

*168* **гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн** *1811001096* **тоот гэрчилгээтэй**

*„Аварга тосон хэнтий„ ХХК* **-д**

**энэхүү тусгай зөвшөөрлийг** *2037-02-09 дуустал* **жилийн хугацаагаар олгов.**

**Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.**

**ДАРГА** **Д. БАТХУЯГ**

*2010 оны 02 сарын 12 өдөр*

*Улаанбаатар хот*

**15479А**

# АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . . . . . . ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

*(тусгай зөвшөөрөлгүй бол хүчингүй)*

*Тусгай зөвшөөрлөөр талбайн хэмжээ болон тусгай зөвшөөрлийн эзэмшилд орсон өөрчлөлт*

| д/д | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Өргөдлийн бүртгэлийн дугаар | Хасагдах талбайн хэмжээ (га-аар) | Үлдэх талбайн хэмжээ (га-аар) |
|---|---|---|---|---|
| | **10613А тоот гэрчилгээг үрэгдүүлсэн тул ГУУКХ-ийн даргын 2010 оны 201 тоот шийдвэрээр 1811001096 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй “Аварга тосон хэнтий,, ХХК-д нөхөн олгов** <br>*Анх олгосон огноог 2005-10-07-оор тооцно.* | | | **168** <br>**2010-02-12** |
| 1. | **Анх олгосон** | **15501А** | | **168** <br>**2005-10-07** |
| 2. | **Тусгай зовшоорлийн хоёр дахь жилийн толбороо толов** | | | **168** <br>**2006-10-06** |
| 3. | **Тусгай зовшоорлийн гурав дахь жилийн төлбороо толов** | | | **168** <br>**2007-10-15** |
| 4. | **Лицензийн доров дахь жилийн толбороо толов** | | | **168** <br>**2008-10-13** |
| 5. | **Тусгай зовшоорлийн тав дахь жилийн толборийг төлөв** | | | **168** <br>**2009-09-29** |

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-015479**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 012-SPR | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөх<br>• Кадастрын хэлтсийн даргын 2013.06.04-ний 241 тоот шийдвэр | 2013-06-04 |
| 013-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.10.07 – 2014.10.07 хүртэл | 2013-10-09<br>01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС |
| 014-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.10.07 – 2015.10.07 хүртэл | 2014-10-06<br>01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС |
| 015-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.10.07 – 2016.10.07 хүртэл | 2015-10-08<br>01 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058 |
| 016-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.10.07 – 2017.10.07 хүртэл | 2016-10-07<br>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС |
| 017-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.10.07 – 2018.10.07 хүртэл | 2017-10-10 |
| 018-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.10.07 – 2019.10.07 хүртэл | 2018-10-08<br>1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ҮХА0595 |

**15479A**

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . . . . . . . ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2 ДУГААР ХАВСРАЛТ

*(тусгай зөвшөөрөлгүй бол хүчингүй)*

*Тусгай зовшоорлоор олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын оорчлолтүүд*

| д/д | Солбицлууд оорчлогдох үндэслэл | Хүчин тоголдор солбицлууд |
|---|---|---|
| ~~1.~~ | ~~Талбайн солбицлууд~~ | |

| No | град | мин | сек | град | мин | сек | No | град | мин | сек | град | мин | сек |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 104 | 30 | 56.8 | 48 | 13 | 12.67 | 4 | 104 | 31 | 35.45 | 48 | 13 | 11.9 |
| 2 | 104 | 31 | 13.65 | 48 | 13 | 12.67 | 5 | 104 | 31 | 35.45 | 48 | 12 | 4 |
| 3 | 104 | 31 | 17.63 | 48 | 13 | 11.91 | 6 | 104 | 30 | 56.8 | 48 | 12 | 4 |

2005-10-07 А.Очгэрэл

| д/д | Солбицлууд оорчлогдох үндэслэл | Хүчин тоголдор солбицлууд |
|---|---|---|
| 2. | Тусгай зовшоорлийн хоёр дахь жилийн толбороо толов | Тусгай зовшоорлоор олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2006-10-06 |
| 3. | Тусгай зовшоорлийн гурав дахь жилийн толбороо толов | Тусгай зовшоорлоор олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2007-10-15 |
| 4. | Тусгай зовшоорлийн дөров дахь жилийн толборийг толов | Тусгай зовшоорлоор олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2008-10-13 |
| 5. | Тусгай зовшоорлийн тав дахь жилийн толборийг толов | Тусгай зовшоорлоор олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 2009-09-29 |

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

# ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

## Кадастрын лавлагаа

### Лавлагааны мэдээлэл

Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

| | |
|---|---|
| Тусгай зөвшөөрлийн дугаар | MV-015479 |
| Талбайн нэр | Ар наймганы доод хэсэг |
| Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га | 163.72 |
| Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр | Рэдвулкан |
| Аймаг, сум, сав газрын нэр | Төв аймаг Заамар сум, Туул голын сав газар |
| Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх | давхцалгүй |
| Давхацсан талаарх мэдээлэл | |




ТАНИХ ТЭМДЭГ

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл**
- Ашиглалтын
- Хайгуулын

**Засаг захиргааны хил**
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв

